

МОНГОЛБАНКНЫ МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ХУРААНГУЙ ТЭМДЭГЛЭЛ

№ 25/3

Улаанбаатар хот

Монголбанкны Мөнгөний бодлогын хороо (МБХ) 2025 оны 6 дугаар сарын 12, 13-ны өдрүүдэд хуралдаж, хуралдааныг Монголбанкны Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн удирдав. Хуралдааны эхний өдөр мөнгөний бодлогын хэрэгжилт, эдийн засаг, банкны салбарын өнөөгийн байдлын талаар Монголбанкны хариуцсан газрууд танилцууллаа. Хуралдааны дараагийн өдөр эдийн засгийн цаашдын төлөв, бодлогын саналыг Мөнгөний бодлогын газар (МБГ)-аас танилцуулж, хэлэлцүүлэг өрнүүлэв.

Хурлын эхний өдөр Санхүүгийн зах зээлийн газар (СЗЗГ)-аас мөнгөний бодлогын хэрэгжилт, мөнгөний захад гарсан өөрчлөлтүүдийн талаар танилцуулав. Энэ оны эхний 5 сарын байдлаар гадаад валютын орох урсгал өмнөх оны мөн үеэс 23 хувиар, гарах урсгал 6 хувиар тус тус буурчээ. Гадаад валютын орох урсгал ийнхүү буурахад нүүрсний хилийн үнэ энэ оны эхнээс 24 орчим хувиар буурч, экспортын орлого багассан нь голлон нөлөөлөв. Түүнчлэн, машин, тоног төхөөрөмж, шатахууны импортын хэмжээ багасаж, валютын гарах урсгал саарахад нөлөөлсөн байна. Улмаар гадаад валютын урсгал цэвэр дүнгээр энэ оны эхнээс 298 сая ам.долларын алдагдалтай гарч, гадаад валютын албан нөөц 5 дугаар сарын байдлаар 5.2 тэрбум ам.долларт хүрснийг танилцуулав. ТБҮЦ-ны үлдэгдэл оны эхнээс 28 хувиар буурч, 2025 оны 5-р сарын эцэст 8.3 их наяд төгрөгт хүрсэн бөгөөд үүнд, гадаад өрийн төлбөр хийгдсэн, төлбөрийн тэнцлийн алдагдалтай холбоотойгоор гадаад цэвэр активын өсөлт саарсан, банкуудын төгрөг болон гадаад валютын заавал байлгах нөөцийн хувь хэмжээ нэмэгдсэн зэрэг нь голлон нөлөөлжээ. Үргэлжлүүлэн, банк хоорондын захын арилжаа, ипотекийн зээлийн санхүүжилт болон валютын ханшийн өөрчлөлтийн талаар танилцуулав.

Банкны бүтцийн өөрчлөлт, бодлогын газар (ББӨБГ)-аас банкны салбарын өнөөгийн байдлын талаар танилцууллаа. Банкны системийн нийт актив 2025 оны 1 дүгээр улиралд өмнөх оноос 15.0 их наяд төгрөгөөр буюу 27.4 хувиар, нийт пассив 13.7 их наяд төгрөгөөр буюу 28.3 хувиар тус тус өссөн байна. Банкны системийн зээлийн үлдэгдэл энэ оны эхний улиралд 38.5 их наяд төгрөгт хүрч, өмнөх оноос 33.1 хувиар буюу 9.6 их наяд төгрөгөөр өссөн бөгөөд өсөлтийн дийлэнх хэсгийг иргэдийн зээл бүрдүүлсэн хэвээр байна. Банкны системийн чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх харьцаа 2024 оны эцэстэй харьцуулахад 0.3 хувиар өссөн байна. Цаашлаад, банкуудын төлбөр түргэн гүйцэтгэх чадвар, зохистой харьцааны биелэлт, ашигт ажиллагааны үзүүлэлтүүд болон Засгийн газрын хүүгийн дэмжлэгтэй зээлийн хөтөлбөрүүдийн талаар танилцууллаа.

Хурлын дараагийн хэсэгт МБХ-ны гишүүдэд макро зохистой бодлогын симуляц шинжилгээний үр дүнг анх удаа танилцууллаа. 2008-2009 оны дэлхийн санхүүгийн хямралын дараа төв банкууд санхүүгийн системийн эрсдэлийг хянах, тогтвортой байдлыг хангахад анхаарал хандуулах болсон. Энэ хүрээнд Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 2018 онд орсон нэмэлт өөрчлөлтөөр Монголбанк үнийн тогтвортой байдлыг хангах үндсэн зорилтын хүрээнд санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангах, системийн эрсдэлээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн макро зохистой бодлогыг хэрэгжүүлэх чиг үүрэг нэмэгдсэн байна. Макро зохистой бодлогын шийдвэр гаргахад

шаардлагатай шинжилгээний арга зүйг хөгжүүлж, мөнгөний бодлоготой хослуулан хэрэгжүүлэх хүрээнд эдийн засаг, санхүүгийн сектор хоорондын харилцан хамаарлыг тусгасан бүтцийн, хураангуй загварыг хөгжүүлж, бодлогын шинжилгээнд ашиглаж эхэлж байгааг онцоллоо. Үргэлжлүүлээд, макро-санхүүгийн загварын ерөнхий бүтэц, онцлог шинж чанарыг танилцуулж, i) макро эрсдэл нэмэгдэх, ii) нүүрсний экспортын шок бий болох, iii) мөчлөг сөрсөн өөрийн хөрөнгийн шаардлага нэмэгдэх, iv) хэрэглээний зээлийн өсөлт буурах, v) тусгай эрсдэлийн сан байгуулах зэрэг хувилбар шинжилгээний үр дүнг танилцууллаа.

Хурлын сүүлийн өдөр бодлогын саналыг эдийн засгийн суурь төсөөлөл, түүнд ашигласан таамаглалт нөхцөлүүд, хувилбар төсөөллүүдэд үндэслэн танилцуулав. Инфляц сүүлийн саруудад саарч, 2025 оны 5 дугаар сард улсын хэмжээнд 8.3 хувь, Улаанбаатар хотын хэмжээнд 9.4 хувьд хүрч буурлаа. Үүнд, мах, гурил зэрэг хүнсний гол нэрийн бүтээгдэхүүн болон импортын барааны үнийн өсөлт саарсан нь голлон нөлөөлөв. Түүнчлэн, Засгийн газрын 3 дугаар сарын 12-ны өдрийн шийдвэрийн дагуу төрийн зохицуулалттай үйлчилгээний үнэ энэ онд өсөхөөргүй болсон, нийлүүлэлт, зардлын шалтгаантай үнийн дарамт хүлээлтээс бага байгааг харгалзан энэ оны инфляцын төсөөллийг өмнөхөөс буурууллаа. Хэдийгээр инфляц хүлээлтээс эрт саарах хандлага ажиглагдсан ч нийтийн тээвэр, цахилгаан зэрэг төрийн зохицуулалттай үйлчилгээний үнийн өсөлтийн суурь нөлөөгөөр инфляц зорилтоос өндөр байхаар байна. Инфляц энэ оны сүүлээс алгуур саарсаар 2026 оны эхнээс төв банкны зорилтот интервалд тогтворжих хүлээлттэй байгааг танилцууллаа.

Эдийн засаг 2025 оны эхний улиралд 2.4 хувиар өслөө. Нүүрсний үнийн бууралтыг дагаад тээврийн салбар 21.6 хувиар агшсанаас гадна төрийн байгууллагын хэрэглээ, импортын өсөлт саарч бүтээгдэхүүний цэвэр татвар, худалдааны салбарын үйлдвэрлэл өмнөх оноос буурав. Ийнхүү тээвэр, худалдаа, бүтээгдэхүүний цэвэр татвар нийтдээ 2.2 нэгж хувийн сөрөг нөлөөг үзүүлсэн байна. Харин өвөл, хаврын саруудад малын зүй бус хорогдол харьцангуй бага байж, хөдөө аж ахуйн салбар оны эхний улиралд 35.6 хувиар тэлснээр нийт өсөлтөд 1 нэгж хувийн эерэг нөлөөг үзүүллээ. Эдийн засгийн идэвхжил хүлээлтээс сул байгааг харгалзан энэ оны өсөлтийн төсөөллийг 6.0 хувьд болгож өмнөхөөс буурууллаа. Дунд хугацаанд гадаад эрэлт буурах, худалдааны нөхцөл муудах, хөрөнгө оруулалтын урсгал багасах нь эдийн засгийн өсөлтийн төлөвийг сааруулахаар байна.

Төсвийн тэнцвэржүүлсэн орлого 2025 оны 4 дүгээр сард өмнөх оны мөн үеэс 1.4 их наяд төгрөгөөр буурч, тэнцвэржүүлсэн тэнцэл 58 тэрбум төгрөгийн алдагдалтай гарлаа. Үүнд, уул уурхайн компаниудын орлого буурсантай холбоотойгоор ААНОАТ¹ 1.1 их наяд төгрөгөөр, нүүрсний экспортын үнэ буурснаар АМНАТ² 940 тэрбум төгрөгөөр тус тус саарсан нь нөлөөлөв. Ийнхүү төсвийн орлого бүрдүүлэлт муу байгаагаас энэ онд нэгдсэн төсвийн зардлыг батлагдсан дүнгээс 2.1 их наяд төгрөгөөр танагдахаар суурь төсөөлөлд авч үзсэн.

Мөнгөний нийлүүлэлтийн өсөлт сүүлийн 10 сарын турш саарч, 2025 оны 4 дүгээр сард 8.9 хувьд хүрлээ. Үүнд, төлбөрийн тэнцлийн алдагдалтай холбоотойгоор банкны системийн гадаад цэвэр активын өсөлт саарсан нь голлон нөлөөлөв. Нөгөө талаас нийт

¹ Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар

² Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр

зээлийн өсөлт³ 31.0 хувьд хүрч, мөнгөний нийлүүлэлтийн өсөлтийг тэтгэсэн хэвээр байна. Зээлийн зориулалтаар нь авч үзвэл, энэ оны 3 дугаар сараас хэрэглээний зээлд макро зохистой бодлогын арга хэмжээг хэрэгжүүлсэн бөгөөд хэрэглээ, хадгаламж барьцаалсан зээлийн өсөлт 3, 4 дүгээр саруудад илүү саарах хандлагатай байгааг танилцууллаа. Нөгөө талаас бизнесийн зээлийн өсөлт өндөр түвшинд хадгалагдсан хэвээр байна. Эдийн засгийн салбараар авч үзвэл, бизнесийн зээлийн өсөлтийн дийлэнхийг худалдаа, үйлчилгээ, уул уурхайн, хөдөө аж ахуйн салбарын зээлүүд бүрдүүлж байна. Цаашид төлбөрийн тэнцлийн алдагдал үргэлжилж, зээлийн өсөлт саарахаар байгаагаас мөнгөний нийлүүлэлтийн өсөлт нам түвшинд хадгалагдах хүлээлттэй байна.

Үргэлжлүүлээд, гадаад эдийн засаг болон төлбөрийн тэнцлийн нөхцөл байдлыг танилцууллаа. Гадаад орчны хувьд улс орнууд хоорондын худалдааны зөрчилдөөн ширүүсэж, гадаад орчны тодорхой бус байдал нэмэгдэн, дэлхийн эдийн засгийн өсөлтийн төсөөлөл огцом буурлаа. Манай улсын худалдааны гол түнш БНХАУ-ын эдийн засгийн өсөлт 2025 оны эхний улиралд төрөөс хэрэгжүүлж буй өсөлтийг дэмжих бодлогын нөлөөгөөр хүлээлтээс өндөр гарсан ч цаашид буурах эрсдэл хэвээр байгааг шинжээчид анхааруулж байна. Цаашлаад дэлхийн зах зээлд нүүрсний үнэ тасралтгүй буурч байгаа нь манай улсын эдийн засаг, экспортын орлогод сөргөөр нөлөөлж байгаа бөгөөд нүүрсний үнийн бууралт нь 2025 оны 1 дүгээр улиралд төлбөрийн тэнцэл 602 сая ам.долларын алдагдалтай гарах гол хүчин зүйл болжээ. Энэ оны үлдсэн хугацаанд нүүрсний үнэ төдийлөн сэргэхээргүй байгаа тул экспортын орлого багасах, ойрын хугацаанд хэрэгжиж эхлэх томоохон дэд бүтцийн болон эрчим хүчний төслүүд нь импортын эрэлтийг нэмэгдүүлэх зэргээс шалтгаалан төлбөрийн тэнцэл энэ онд болон ирэх онуудад алдагдалтай байх төсөөлөлтэй байна. Ийнхүү гадаад худалдаа, урсгал тэнцэлтэй холбоотойгоор гадаад секторын эмзэг байдал өндөр байгааг онцоллоо.

Танилцуулгын сүүлийн хэсэгт тэтгэврийн зээлийн нөхцөл байдлыг танилцуулав. Мөнгөний бодлогын хороо (МБХ)-ны 2025 оны 1 дүгээр улирлын ээлжит хуралдаанаар тэтгэврийн зээлдэгчдийн санхүүгийн эрсдэл, эмзэг байдлыг бууруулах, нийгмийн баталгааг хангах хүрээнд тэтгэврийн орлого барьцаалсан зээлдэгчийн зээлийн төлбөрийн дараах орлого нь амьжиргааны баталгаажих доод түвшнээс доошгүй байхаар шийдвэрлэсэн билээ. Уг арга хэмжээг мөрдүүлж эхэлснээр тэтгэврийн зээлийн үлдэгдэл 2025 оны 4 дүгээр сард 1.8 их наяд төгрөгт хүрч, арга хэмжээ мөрдүүлэхээс өмнөх үе буюу 2 дугаар сартай харьцуулахад 254.9 тэрбум төгрөгөөр буурсан байна. Гэсэн хэдий ч одоогийн зохицуулалтаар өрийн хязгаартаа тултал тэтгэврийн зээл авч, сар бүр зээлээ сунгах замаар амьжиргаагаа залгуулж буй зарим иргэдийн хувьд зээлээ сунгаж чадахгүй хүндрэлтэй нөхцөл байдал үүссэн байгааг танилцуулав. Хэдийгээр ийм хэлбэрээр зээлийг зээлээр санхүүжүүлж, сар бүрийн тэтгэврийн орлогоосоо нэмэлтээр зээлийн хүү төлөх нь тэтгэвэр авагч иргэдийн бодит орлогыг бууруулж, амьжиргааны чанарыг муутгаж байгаа боловч эдгээр зээлдэгчдэд үүсээд буй асуудлыг харгалзан үзэж шилжилтийн үеийн зохицуулалт хийх хүсэлтийг ГБХНХЯ⁴ -наас удаа дараа Монголбанканд ирүүлээд байна. Энэ хүрээнд одоогийн хэрэгжиж буй зохицуулалтыг алгуур сулруулж, ирэх хоёр жилд зээлийн үлдэгдлийг шат дараатайгаар бууруулах бодлогын хувилбар тооцооллуудыг танилцууллаа.

³ Ипотекийн зээлээр баталгаажуулсан бондыг оруулсан

⁴ Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам

Ийнхүү МБГ-аас эдийн засаг, банк, санхүүгийн салбарын нөхцөл байдал, инфляцын цаашдын төлөв, эрсдэлийг харгалзан; i) бодлогын хүүг 12 хувьд хэвээр хадгалах, ii) банкнаас шинээр олгох болон тус шинээр олгосон зээлийн нөхцөлийг нь өөрчлөх тэтгэвэр, тэтгэмжийн орлого барьцаалсан зээлийн хувьд өр, орлогын харьцааны дээд хязгаарыг 50 хувиар тогтоох, iii) тэтгэвэр, тэтгэмжийн орлого барьцаалсан зээлийн үлдэгдэлтэй зээлдэгчдийн хувьд зээлийн үлдэгдлийг шат дараатайгаар бууруулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх саналуудыг дэвшүүллээ. Ингээд гишүүдийн зүгээс дээрх саналуудтай холбоотой асуулт асууж, хэлэлцүүлэг өрнүүллээ.

Бодлогын хүүг хэвээр хадгалах саналын тухайд экспортын гол түүхий эдүүдийн үнэ буурч, гадаад худалдаа болон төлбөрийн тэнцлийн эмзэг байдал цаашид үргэлжлэхээр байна. Нэг гишүүний хувьд гадаад секторын эмзэг байдал, эрсдэлийг харгалзан үзээд бодлогын хүүг 1 нэгж хувиар нэмэгдүүлэх ч боломжтой болохыг илэрхийлэв. Цаашлаад, зарим гишүүд гадаад эдийн засгийн тодорхой бус байдал нэмэгдэж, гадаад хүү буурах хурд удааширч буй өнөөгийн нөхцөлд мөнгөний бодлогын тохиргоог болгоомжтой хийх нь зүйтэй гэсэн байр суурийг илэрхийлэв. Түүнчлэн, төсвийн орлого тасалдаж, төсвийн эмзэг байдал өндөр байгаа одоогийн нөхцөлд мега төслүүд дотоод эх үүсвэрээр хэрэгжих зэрэг нөхцөл байдал үүсвэл валютын урсгал, ханшид хүчтэй дарамт учруулж, инфляц өдөөгдөх эрсдэлтэй байна. Улмаар гадаад, дотоод эдийн засгийн өнөөгийн байдал, цаашдын эрсдэлийг харгалзан үзээд бодлогын хүүг 12 хувьд хадгалах саналыг бүх гишүүд дэмжлээ.

Хуралдааны дараагийн хэсэгт, банкнаас шинээр олгох болон тус шинээр олгосон зээлийн нөхцөлийг нь өөрчлөх тэтгэвэр, тэтгэмжийн орлого барьцаалсан зээлийн хувьд өр, орлогын харьцаа (ӨОХ)-ны дээд хязгаарыг 50 хувиар тогтоох саналын талаар хэлэлцэв. Нэг гишүүний зүгээс тэтгэврийн зээлийн өсөлт нь импортыг өдөөж, гадаад валютын нөөц, ханшид дарамт учруулах эрсдэлтэй боловч зээлдэгчдийн санхүүгийн хэрэгцээ, шаардлагыг харгалзан зохицуулалтыг өмнө нь авч хэрэгжүүлснээс сулруулж, өр, орлогын харьцааг 50 хувиар тогтоох нь зүйтэй гэсэн саналыг илэрхийлэв. Өөр нэг гишүүн банкнаас шинээр олгох тэтгэврийн зээлийн ӨОХ-ны дээд хязгаарыг 50 хувиар тогтоох нь бусад хэрэглээний зээлийн нөхцөлтэй нийцтэй байгааг онцлов. Ийнхүү тус арга хэмжээг хэрэгжүүлэхийг МБХ-ны гишүүд 100 хувийн саналаар дэмжив.

Харин тэтгэврийн зээлийн үлдэгдэл өндөр, дахин зээл авч амьжиргаагаа залгуулах шаардлагатай иргэдийн хувьд шилжилтийн үеийн зохицуулалт хийх нь зүйтэй боловч ийнхүү нарийн, төвөгтэй байдлаар томьёолох нь иргэдэд ойлгомжгүй байдал үүсгэж болзошгүйг анхааруулав. Мөн тэтгэврийн зээлийн үлдэгдэлтэй иргэд ба шинээр тэтгэврийн зээл авч буй иргэдийн хувьд зохицуулалт ялгаатай байх нь шүүмжлэл дагуулж болзошгүйг санууллаа. Улмаар нэг гишүүний зүгээс шилжилтийн үеийн зохицуулалтыг арилжааны банкууд өөрсдөө зээлийн эрсдэл, зээлдэгчийн санхүүгийн шаардлага зэргийг харгалзан хийх талаар чиглэл өгөх нь зүйтэй гэсэн саналыг дэвшүүллээ. Бусад гишүүдийн зүгээс тус саналыг дэмжиж буйгаа илэрхийлээд, тэтгэврийн зээлийн үлдэгдэлтэй иргэдэд Монголбанкнаас ямар нэг тусгай зохицуулалт хийхгүй бөгөөд банкууд өөрсдөө зээлдэгчийн төлбөрийн дарамт, санхүүгийн хэрэгцээг харгалзан уян хатан зохицуулалт хийх нь зүйтэй гэж үзлээ. Тус саналыг зөвлөмж байдлаар МБХ-ны шийдвэртэй хамт арилжааны банкуудад хүргүүлэх талаар бодлогын газруудад чиглэл өгч, МБХ-ны 2025 оны 2 дугаар улирлын ээлжит хуралдаан өндөрлөв.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны 2025 оны 6 дугаар сарын 12, 13-ны өдрийн ээлжит хурлаар эдийн засаг, банк, санхүүгийн зах зээлийн өнөөгийн байдал, дотоод, гадаад орчны төлөв, эрсдэлийг харгалзан үзээд:

1. Бодлогын хүүг 12 хувьд хэвээр хадгалах;
2. Банкнаас шинээр олгох болон тус шинээр олгосон зээлийн нөхцөлийг нь өөрчлөх тэтгэвэр, тэтгэмжийн орлого барьцаалсан зээлийн хувьд өр, орлогын харьцааны дээд хязгаарыг бусад хэрэглээний зээлийн адилаар 50 хувиар тогтоохоор шийдвэрлэлээ.

Бодлогын саналын шийдвэр

